



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Г.Чагдаржавын гудамж 1-101 тоот, Нарлаг баг,  
Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48090  
Утас: 7059-2555, Факс: 7059-2555  
Цахим шуудан: dundgovi@gazar.gov.mn  
Цахим хуудас: gov.mn

2026.06.18 № 01/300

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.14 дэх хэсгийг “Нийслэлээс хөдөө орон нутагт шилжин ирсэн, гамшиг ослын улмаас орон гэргүй болсон, эсхүл нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар эзэмших хүсэлтийг эрэмбэ, дараалал харгалзахгүй шийдвэрлэх бөгөөд нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрэмбэ дараалал харгалзахгүй шийдвэрлэх хүсэлтийн хувь, хэмжээг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр тогтооно.” гэж өөрчлөх саналыг хүргүүлж байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээллийн сангаас судалж үзэхэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй нийт 107904 иргэн байна. Гэтэл сүүлийн жилүүдэд Улсын хэмжээнд тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, зориулалтын жагсаалтаар шинээр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар дунджаар 30000 гаруй нэгж талбар батлагдаж байгаа. Мөн тухайн орон нутгийн газрын нөөц, газар зохион байгуулалт болон хотын хөгжлийн төлөвлөгөөнөөс шалтгаалж төлөвлөх нэгж талбарын тоо болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо харилцан адилгүй байдаг. Үүнээс шалтгаалж тухайн орон нутгийн бусад иргэдэд газар олгох боломжгүй байх нөхцөл байдал үүсэхээр байна.

Иймд хуульд заасан иргэдийн хүсэлтийг шийдвэрлэх хувь хэмжээг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хэд байхыг тогтоох асуудлыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэдэг байх нь зүйтэй юм.



Дундговь аймгийн газрын харилцаа, барилга, хот  
байгуулалтын газар  
Захиргаа удирдлагын хэлтэс  
Газрын дарга  
Эрдэнэцэцэг Чагнаадорж  
2026-06-18 15:36:30